



**МОНГОЛ УЛСЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, ЭРҮҮЛ МЭНДИЙН
ДААТГАЛЫН САНГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, НИЙГМИЙН
ДААТГАЛЫН САНГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, ҮНДЭСНИЙ
БАЯЛГИЙН САНГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛҮҮДИЙН ГУРАВ ДАХЬ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ЯВЦАД ТӨСВИЙН
ТӨСӨЛД ТУСГУУЛАХААР ГАРГАСАН САНАЛТАЙ
ХОЛБОГДУУЛАН ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН
ЗӨВЛӨЛӨӨС ӨГӨХ ДҮГНЭЛТ**

УЛААНБААТАР ХОТ
2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр

АГУУЛГА

1. Төсвийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийн явцад гарсан саналуудын талаар	3
2. Төсвийн төсөлд тусгуулахаар гаргасан саналууд нь Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23.1-д заасан шалгуурыг хангасан эсэх талаар	4
3. Төсвийн төсөлд тусгуулахаар байнгын хороо, ажлын хэсгээс гаргасан саналуудын 2026 оны төсвийн төсөлд үзүүлэх нөлөөллийн талаар.....	4
Дүгнэлт	6
Зөвлөмж	6

**МОНГОЛ УЛСЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
САНГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2026
ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙН ГУРАВ ДАХЬ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ЯВЦАД
ТӨСВИЙН ТӨСӨЛД ТУСГУУЛАХААР ГАРГАСАН САНАЛТАЙ ХОЛБОГДУУЛАН
ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛӨӨС ӨГӨХ ДҮГНЭЛТ**

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн гурав дахь хэлэлцүүлгийг Төсвийн байнгын хороо 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн хуралдаанаар хийж, олонхын дэмжлэг авсан саналуудыг холбогдох баримтуудын хамт ирүүлсэн.

Эдгээр мэдээлэлд үндэслэн Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16¹.5.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 24.2 дахь заалтын дагуу гурав дахь хэлэлцүүлгийн явцад төсөвт тусгуулахаар гаргасан саналтай холбогдуулан дүгнэлт гаргалаа. Төсөвт тусгуулахаар гаргасан саналууд нь хуулийн дээрх заалтуудаас гадна Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн (ТТБТХ) 6 дугаар зүйлд тусгагдсан “Төсвийн тусгай шаардлага”-д нийцсэн эсэх, Төсвийн тухай хуулийн 6.2.6, 29.3.5, 29.4 болон 29¹.2.2-т заасан шалгууруудыг хангасан эсэхийг харгалзан үзсэн болно.

1. Төсвийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийн явцад гарсан саналуудын талаар

1.1. Хэлэлцүүлгийн явцад гарсан саналын 27.6 хувь нь дэмжигдсэн байна. Төсвийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийн үеэр Байнгын болон дэд хороо, ажлын хэсгийн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүдээс төсвийн орлого, зарлагыг өөрчлөхтэй холбоотой нийт 112 зарчмын зөрүүтэй санал гаргаснаас 61 саналыг (54.5%) холбогдох Байнгын хороо болон дэд хороо, ажлын хэсгээс, эдгээрээс 31-ийг нь (50.8%) Төсвийн байнгын хорооны хуралдаанаас дэмжсэн байна.

Хүснэгт 1. Гаргасан болон дэмжигдсэн саналын тоо

№	Байнгын болон дэд хороо, Ажлын хэсэг	Гишүүний гаргасан нийт 33СТ-ын тоо	Үүнээс тухайн БХ дэмжсэн 33СТ	ТБХ дэмжсэн 33СТ
1	ТББХ	7	2	
2	ХХНББХ	35	21	
3	ӨБХ	3	2	
4	ЭЗБХ	8	2	
5	БОХХААБХ	10	2	1
6	ХЗБХ	4	1	
7	ЗХДХ	4	0	
8	Ажлын хэсэг	25	25	24
9	ТБХ	16	6	6
	Нийт	112	61	31

1.2. Төсвийн төсөлд тусгуулахаар дэмжигдсэн саналуудын өртөг төсвийн төслийн нийт зарлагын 4.38 хувьтай тэнцэж байна. Төсвийн төсөлд тусгуулахаар дэмжигдсэн саналуудын хувьд урсгал зардлыг **988.6** тэрбум төгрөгөөр бууруулж, **953.6** тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх, хөрөнгийн зардлыг **457.5** тэрбум төгрөгөөр бууруулж, **490.7** тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэхээр байна. Ингэснээр нийт зарлагын өөрчлөлт нь 2026 онд **1,444.3** тэрбум төгрөг болж байгаа нь төсвийн нийт зарлагын 4.38 хувийг эзэлж байна.

2. Төсвийн төсөлд тусгуулахаар гаргасан саналууд нь Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23.1-д заасан шалгуурыг хангасан эсэх талаар

2.1. Төсвийн төслийн өөрчлөлт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасан шалгуурыг хангаж байна. Төсвийн байнгын хороогоор дэмжигдсэн саналууд төсвийн зарлагыг **1,446.05** тэрбум төгрөгөөр бууруулж, **1,444.3** тэрбум төгрөгөөр өсгөхөөр байна. Энэ нь Үндсэн хуульд заасан “Улсын төсвийг хэлэлцэн батлахдаа төсвийн орлого, зарлагын бүтцийг өөрчилж болно. Ингэхдээ Засгийн газрын өргөн мэдүүлсэн төсвийн зарлагын болон алдагдлын хэмжээг нэмэгдүүлж үл болно” гэсэн заалттай нийцэж байна.

2.2. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагыг хангаж байна. Байнгын хороогоор хэлэлцэгдсэн саналууд Засгийн газраас 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр өргөн барьсан төсвийн төслийн орлого, зарлагын хэмжээг өөрчлөхөөр байгаа хэдий ч Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6-р зүйлд заасан тусгай шаардлагыг хангаж байна.

3. Төсвийн төсөлд тусгуулахаар байнгын хороо, ажлын хэсгээс гаргасан саналуудын 2026 оны төсвийн төсөлд үзүүлэх нөлөө

3.1. Урсгал зардлын өөрчлөлт 2026 оны төсвийн төсөлд тусгагдсан нийт урсгал зардлын 3.88 хувийг эзэлж байна. Төсвийн байнгын хорооны төсвийн гурав дахь хэлэлцүүлгээр дэмжигдсэн зарчмын зөрүүтэй саналуудаар 23 үйл ажиллагааны урсгал зардал 988,590.8 сая төгрөгөөр буурч, 15 үйл ажиллагааны урсгал зардал 953,608.1 сая төгрөгөөр нэмэгдэхээр байгаа нь урсгал зардлын **3.88** хувьтай тэнцэж байна.

3.2. Хөрөнгийн зардлын өөрчлөлт цаашид уг зардлыг өсгөх магадлалтай байна. Доорх хүснэгтэд харуулснаар давхардсан 230 арга хэмжээг төсвийн төслөөс хасах болон төсөвт өртөг, 2026 онд санхүүжих дүнг нь бууруулах замаар зохицуулалт хийгдсэн байна.

Хүснэгт 2. Хөрөнгийн зардлаас хассан, дүн бууруулсан төсөл, арга хэмжээний мэдээлэл

Үзүүлэлт	Хассан		Тодорхой дүнгээр бууруулсан	
	Төсөвт өртөг	2026 онд санхүүжих дүн	Төсөвт өртөг	2026 онд санхүүжих дүн
Төсөл, арга хэмжээний тоо	2	2	30	196
Өөрчлөлтийн дүн, сая төгрөг	32,676.1	13,143.2	120,560.3	444,320.6

Үүний нөгөө талд 144 арга хэмжээг нэмж зардлыг өсгөхдөө 138 арга хэмжээг шинээр нэмж, 6 арга хэмжээний зардлыг нэмэгдүүлсэн нь хассан арга хэмжээнүүдийн 2026 онд санхүүжих дүнгээс 33,262.3 сая төгрөгөөр илүү байна.

Хүснэгт 3. Хөрөнгийн зардалд шинээр нэмсэн, төсөвт өртөгийг нэмэгдүүлсэн төсөл арга хэмжээний мэдээлэл

Үзүүлэлт	Нэмсэн		Тодорхой дүнгээр нэмэгдүүлсэн	
	Төсөвт өртөг	2026 онд санхүүжих дүн	Төсөвт өртөг	2026 онд санхүүжих дүн
Төсөл, арга хэмжээний тоо	138	138	6	5
Өөрчлөлтийн дүн, сая төгрөг	1,535,060.3	477,611.6	108,215.0	13,114.5

Түүнчлэн хөрөнгийн зардлыг нэмэгдүүлсэн дүнд хамаарах хөрөнгө оруулалтын төсөвт өртөг нь бууруулсан хөрөнгийн зардлаас **1,490.0** тэрбум төгрөгөөр их байгаа нь дунд хугацаанд төсвийн хөрөнгийн зардалд нөлөөлөх өөрчлөлт болсон байна.

3.3. Шинээр нэмж байгаа зарим төсөл, арга хэмжээ Төсвийн тухай хуулийн хэд хэдэн шалгуурт нийцэхгүй байна. Төсвийн байнгын хороогоор дэмжигдсэн төсөл арга хэмжээнүүд нь Төсвийн тухай хуулийн шалгуурыг бүрэн хангахгүй байгаа бөгөөд дараах зөрчил илэрч байна. Үүнд:

3.3.1. Хөрөнгө оруулалтын 341 төсөл, арга хэмжээнээс 67 нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5-д заасан *“шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож, гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах”* гэсэн шаардлагад нийцээгүй (Хавсралт).

3.3.2. Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т заасны дагуу *“Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөл нь батлагдсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана”* гэсэн шаардлагад нийцэхгүй 12 төсөл, арга хэмжээ байна (Хавсралт).

3.3.3. Техник, эдийн засгийн үндэслэл, магадлал хийгдсэн хэдий ч Төсвийн тухай хуулийн 29¹ дүгээр зүйлийн 29¹.2.2-д заасан *“барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх”* шаардлагад нийцэхгүй 14 төсөл, арга хэмжээ байна (Хавсралт).

3.4. Шинээр төсөл нэмэх зорилгоор өмнө байсан төслийн санхүүжилтийг бууруулах нь төсвийн төсөлд тусгагдсан төслийг шахан гаргах үзэгдлийг бий болгож байна. 3.3.1-т дурдсан 67 төсөл, арга хэмжээний тодорхой хэсэг нь анх өргөн барьсан төсвийн төсөлд тусгагдсан байсан бөгөөд санхүүжилтийг бууруулсан шалтгаанаар Төсвийн тухай хуулийн шаардлагыг хангахгүйд хүрч байгаа нь шинээр төсөл нэмж байгаатай холбоотойгоор сөрөг нөлөөлөл үүсгэхээр байна.

3.5. Төсөл, арга хэмжээг шинээр оруулж ирэхдээ ямар зарчим баримталсан нь тодорхойгүй байна. Нэмэхээр санал болгож байгаа зарим төсөл, арга хэмжээний үр дүнгийн үзүүлэлт тодорхойгүй байгаа нь тэдгээрийн ач холбогдлыг бууруулж байна. Түүнчлэн тоног төхөөрөмжийг зардлыг жигдхэн 50 хувь хасах бодлого баримталж байгаа боловч шинээр тоног төхөөрөмж авах саналууд дэмжигдсэн нь бодлого тууштай биш байгааг харуулж байна.

Дүгнэлт

Төсвийн Тогтвортой Байдлын Зөвлөлөөс Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн гурав дахь хэлэлцүүлгийн явцад төсөвт тусгуулахаар гарсан саналуудтай холбогдуулан дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд

1. “2026 оны төсвийн төслийг хэлэлцэх үйл явцад багш, эмчийн цалин, ахмад настны тэтгэврийг нэмэх асуудал үүссэн нь урсгал зардалтай холбоотой зохицуулалт хийх, төсвийн төсөлд өөрчлөлт оруулах шалтгаан болсон байна” хэмээн үзэж байна.
2. Ийм нөхцөл байдал байсан ч төсвийн төсөлд өөрчлөлт оруулах нь эдийн засгийн нөхцөл байдал, төсвийн бодлого, түүний хэрэгжилт, үр дүнгийн үзүүлэлттэй нягт уялдаатай байх шаардлагатайгаас гадна ирээдүйд гарах эрсдэлийг нэмэгдүүлэхгүй байхад анхаарах шаардлагатай байна.
3. Төсвийн төслийг өөрчлөх саналуудтай холбоотой зарлагын хэт хавтгайрсан таналт, шинээр санаачилж буй төсөл, арга хэмжээний үр нөлөө, эрэмбэ дараатай холбоотойгоор төсвийн төслийн чанар, бодлогод сөрөг нөлөө бий болох талтай байна.

Зөвлөмж

1. Төсвийн төсөлд өөрчлөлт оруулах саналын тоо, мөнгөн дүн нэмэгдэж болзошгүй байгаатай холбоотойгоор цаашид төсвийн төсөлд өөрчлөлт оруулахдаа бодлогын хувьд анхаарах асуудлууд байна.
2. ДХТХМ-ийн хамрах хүрээг өргөтгөж, салбарын зарлагын дунд хугацааны хязгаарыг тодорхойлон батлах замаар төсвийн төсөлд оруулж буй өөрчлөлт нь төсвийн бодлогыг алдагдуулахгүй байх нөхцөлийг хангах.
3. Байнгын хороогоор дэмжигдээгүй санал УИХ-ын чуулганаар орж байгаа нь бодлого, шалгуурт нийцэхгүй санал төсвийн төсөлд тусгагдах орон зайг бий болгож байгааг анхаарч дэмжигдээгүй саналыг хэрхэн хяналт тавих зохицуулалтыг сайжруулах;
4. Сүүлийн жилүүдэд Засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлж буй жилийн төсвийн төсөл нь УИХ-ын Байнгын хороод болон чуулганаар хэлэлцэгдэх шатанд байнга өөрчлөгдөж ирсэн нь УИХ-ын бүрэн эрхийн асуудал мөн боловч тооцоо, судалгаагүй, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл нь тодорхойгүй хөрөнгийн болон урсгал зардлууд нэмэгдэх, хасагдах, эцсийн дүндээ улсын хөгжлийн бодлого төлөвлөлт болон макро эдийн засгийн бодлогын уялдааг алдагдуулахад хүргэж байна. Иймд Засгийн газар, Сангийн яамны түвшинд төсвийн төлөвлөлтийг, УИХ-ын түвшинд төсвийн төслийг хэлэлцүүлэхэд баримтлах зарчмаа сайжруулах шаардлагатай байна.

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ

2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр

**ОЛОНХЫН ДЭМЖЛЭГ АВСАН ТӨСВИЙН САНАЛУУДЫН ТАЛААРХ ЗАРИМ
МЭДЭЭЛЭЛ**

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх	Дуусах
Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5 “шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож, гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах,” гэсэнтэй нийцээгүй			
1.	Шинжлэх Ухаан Теннологийн Их Сургуулийн оюутны дотуур байрын барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2026	2028
2.	Үерийн хамгаалалтын далангийн байгууламж, 5 км /Завхан, Улиастай сум, Жаргалант, Чигэстэй баг/	2026	2027
3.	Гал түймэр унтраах, аврах ангийн барилга /Хөвсгөл, Тариалан сум/	2026	2028
4.	Гал түймэр унтраах, аврах ангийн барилга /Өвөрхангай, Арвайхээр сум/	2026	2028
5.	Гал түймэр унтраах, аврах ангийн барилга /Баянхонгор, Баянхонгор сум/	2026	2028
6.	Гал түймэр унтраах, аврах ангийн барилга /Завхан, Тосонцэнгэл сум/	2026	2027
7.	Цагдаагийн газрын барилга /Булган, Булган сум/	2026	2028
8.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны, цагдан хорих байрны барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум/	2026	2027
9.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын барилга /Өвөрхангай, Хархорин сум/	2026	2028
10.	Хилийн цэргийн 0303 дугаар ангийн барилга байгууламжийн шинэчлэл /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	2026	2028
11.	Хилийн цэргийн ангийн албан хаагчдын орон сууцны барилга /Хөвсгөл, Цагаан-Уул сум/	2026	2028
12.	Гадаадын иргэн харьяатын газрын барилга /Баян-Өлгий, Өлгий сум/	2026	2027
13.	Хилийн цэргийн 0257 дугаар ангийн спорт заалны барилга /Хөвсгөл, Мөрөн сум/	2026	2027
14.	Хилийн цэргийн 0243 дугаар ангийн авто гарааж, авто засварын барилга /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	2026	2027
15.	Хилийн цэргийн 0286 дугаар ангийн хилийн салбарын барилга байгууламж /Булган, Сэлэнгэ сум/	2026	2028
16.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны, цагдан хорих байрны барилга /Баян-Өлгий, Өлгий сум/	2026	2028
17.	Дотоод хэргийн их сургуулийн цогцолборын Хилийн албаны сургуулийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2026	2028
18.	Тусгай зориулалтын төвийн барилга /Улаанбаатар/	2026	2027
19.	Зэвсэгт хүчний дүгээр ангийн тусгай сургалт бэлтгэлийн төв /Төвийн бүс/	2026	2027
20.	Тусгай зориулалтын барилга байгууламж, дэд бүтэц /Баруун бүс/	2026	2027
21.	Тусгай зориулалтын барилга байгууламж, дэд бүтэц /Төвийн бүс/	2026	2028
22.	Сургуулийн спорт заалын барилга /Сэлэнгэ, Сүхбаатар сум, 1 дүгээр сургууль/	2026	2027

23.	Цэцэрлэгийн барилга, 75 ор /Увс, Наранбулаг сум/	2026	2027
24.	Дотуур байрын барилга, 150 ор /Төв, Зуунмод сум/	2026	2027
25.	Сургуулийн өргөтгөлийн барилга, 320 суудал /Ховд, Жаргалант сум, 2 дугаар баг, 7 дугаар сургууль/	2026	2027
26.	Сургуулийн спорт заалын барилга /Сүхбаатар, Баруун-Урт сум, 1 дүгээр сургууль/	2026	2027
27.	Цэцэрлэг барилга, 200 ор /Сүхбаатар, Баруун-Урт сум, 8 дугаар баг/	2026	2027
28.	Спорт заалын барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум, Баянхайрхан баг/	2026	2027
29.	Дотуур байрын барилга, 75 ор /Сүхбаатар, Халзан сум, 1 дүгээр баг/	2026	2027
30.	Дотуур байрын барилга, 80 ор /Дорнод, Булган сум/	2026	2027
31.	Сургуулийн өргөтгөлийн барилга, 640 Суудал /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 13 дугаар хороо, 122 дугаар сургууль/	2026	2028
32.	Сургуулийн өргөтгөлийн барилга, 640 Суудал /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 33 дугаар хороо, 13 дугаар сургууль/	2026	2028
33.	Сургуулийн барилга худалдаж авах, түрээсийн гэрээний үлдэгдэл санхүүжилт, 960 суудал /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2026	2028
34.	Хангайн бүсийн Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн сувилахуйн сургалт, эрдэм шинжилгээ, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний цогцолборын гадна тохижилт /Архангай, Эрдэнэбулган сум/	2026	2027
35.	Шинэ ховд үйлдвэрлэл технологийн паркийн цахинлгаан хангамж, гол шугам сүлжээний ажил /Ховд, Жаргалант сум/	2026	2027
36.	Шинэ ховд үйлдвэрлэл технологийн паркийн арьс, шир боловсруулах үйлдвэрийн цэвэрлэх байгууламж /Ховд, Жаргалант сум/	2026	2028
37.	Нэгдсэн эмнэлгийн барилга, 100 ор /Булган, Булган сум/	2026	2028
38.	"Хавдар судлалын Үндэсний төв-II" цогцолборын А, С блокийн барилга, гадна шугам сүлжээ /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	2026	2028
39.	Үерийн хамгаалалтын барилга, байгууламж, далан суваг /Дархан-уул, Шарын гол сум/	2026	2028
40.	Үерийн хамгаалалтын барилга, байгууламж, далан суваг /Хөвсгөл, Их-Уул сум/	2026	2027
41.	Үерийн хамгаалалтын далангийн 2, 3 дугаар ээлжийн байгууламж /Архангай, Эрдэнэбулган сум/	2026	2028
42.	Цэвэр усны шугам сүлжээ /Дундговь, Сайнцагаан сум/	2026	2027
43.	Цэвэр усны шугам сүлжээ /Дундговь, Говь-Угтаал сум/	2026	2027
44.	Цэвэр усны шугам сүлжээ /Говь-Алтай, Цээл сум/	2026	2027
45.	"Залуус-1" орон сууцны хорооллын төслийн цахилгаан хангамжийн эх үүсвэрийн угсралтын ажил /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	2026	2028
46.	Инженерийн шугам сүлжээ /Улаанбаатар, Багануур сум/	2026	2027
47.	Инженерийн шугам сүлжээ /Ховд, Дарви сум/	2026	2027
48.	Тосонцэнгэл - Их Уул чиглэлийн 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам /Завхан, Тосонцэнгэл сум/	2026	2027

49.	10 а, б магистраль дулааны шугамын өргөтгөл, шинэчлэл /Улаанбаатар/	2026	2028
50.	Эрдэнэбүрэн-Мянгад чиглэлийн 220 кВ-ын 2 хэлхээ 69 км ЦДАШ, 220/110/35 кВ-ын дэд станц /Ховд, Эрдэнэбүрэн, Мянгад сум/	2026	2028
51.	Бүс нутгийн найдвартай цахилгаан, дулаан хангамж, 2 дугаар үе шат /Улсын хэмжээнд/	2026	2028
52.	Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станцын 2 дугаар хэлхээ, дэд бүтэц /Дундговь, Сайнцагаан сум/	2026	2028
53.	Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станцын 2 дугаар хэлхээний үлдэгдэл, холбоо мэдээлэл /Говьсүмбэр, Сүмбэр сум/	2026	2027
54.	Спорт цогцолборын барилга /Сэлэнгэ, Сайхан сум/	2026	2028
55.	Аялал жуулчлал, спортын цогцолборын барилга /Баян-Өлгий, Өлгий сум/	2026	2027
56.	Спорт заалын барилга /Хөвсгөл, Түнэл сум/	2026	2027
57.	Үүрэн холбооны сүлжээ, дахин дамжуулах станц /Улсын хэмжээнд/	2026	2028
58.	Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенцийн 17 дугаар бага хурал зохион байгуулахтай холбоотой барилга байгууламж /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2026	2026
59.	Улаанбаатар-Мандалговь чиглэлийн авто замаас /Хөшигийн хөндий/ Архивчдын гудамж хүртэлх авто замын өргөтгөл, шинэчлэл /Төвийн бүс/	2026	2028
60.	Баяндалай-Гурвантэс чиглэлийн 80 км хатуу хучилттай авто замын үргэлжлэл, 37 км /Өмнөговь, Баяндалай, Гурвантэс сум/	2026	2028
61.	Бичигт боомтын төв замаас аялал жуулчлалын бүс нутаг Дарьганга-Байгалийн цогцолборт газар хүртэлх хатуу хучилттай авто замын эхлэл /Зүүн бүс/	2026	2028
62.	Хатгал-Ханх чиглэлийн 180 км хатуу хучилттай авто замын эхлэл /Хөвсгөл/	2026	2028
63.	Хэрлэн голын төмөрбетон гүүр, 217.6 у/м /Дорнод, Хэрлэн сум/	2026	2028
64.	Хүнгүйн голын 72.8 у/м төмөр бетон гүүр /Завхан, Ургамал сум/	2026	2027
65.	Булган болон Жаргалант голын гүүр /Баян-Өлгий, Булган сум	2026	2027
66.	“Тусгай зориулалтын барилга байгууламж, дэд бүтэц /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 26,586.5 сая төгрөг, санхүүжих дүн 7,976.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 600.0 сая төгрөгөөр	2026	2028
67.	Тусгай зориулалтын төвийн барилга /Улаанбаатар/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 20,132.1 сая төгрөг, санхүүжих дүн 9,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 300.0 сая төгрөгөөр буюу нийт 1,500.0 сая төгрөгөөр хөрөнгийн зардлыг бууруулж	2026	2027
Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т заасны дагуу “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэсэн шаардлагад нийцэхгүй			
1.	Сумдын хөдөө аж ахуйн үйлдвэрлэл технологийн барилга, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 3,600.0 сая төгрөг	2026	2026

2.	Чойбалсан нисэх буудал /Аэродром/-ын хөөрч, буух зурвас, шинэчлэх /Дорнод, Хэрлэн сум/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг 59,120.0 сая төгрөг, санхүүжих дүн 19,706.6 сая төгрөг	2026	2026
3.	“Уурын зуухны барилгын шугам сүлжээний засвар /Хэнтий, Мөрөн сум/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 600.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр тус тус нэмж тусгах.	2026	2026
4.	Үерийн хамгаалалтын далангийн 2, 3 дугаар ээлжийн байгууламж /Архангай, Эрдэнэбулган сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг нь 10,407.8 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 3,122.4 сая төгрөг” гэсэн арга хэмжээг хасаж	2026	2028
5.	“Газрын тос боловсруулах үйлдвэрийн цахилгаан хангамжийн 110кВ-ын ЦДАШ, 110/35/10кВ-ын Ширээт дэд станц, хэрэгжих хугацаа 2026-2028 он, 16,837.9 сая төгрөг, санхүүжих дүн 3,320.3 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах.	2026	2028
6.	Соёл амралтын хүрээлэнгийн дулааны алдагдалгүй, эрчим хүчний хэмнэлттэй мэдээллийн төвийн барилга /Сүхбаатар, Баруун-Урт сум/	2026	2026
7.	Спорт цогцолбор барилгын зураг төсөв /Увс, Улаангом сум/	2026	2026
8.	Сумын төвийн инженерийн дулааны шугам /Дорноговь, Айраг сум/	2026	2026
9.	Сурагчийн 59 дүгээр гудамжаас 47 дугаар сургуулийн гудамж хүртэлх авто зам, гүүрэн байгууламж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/		
10.	Улаанбаатар-Дарханы төв замаас Хайртхаан чиглэлийн хатуу хучилттай авто зам, 3 км /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 21 дүгээр хороо/	2026	2026
11.	“Шинэ ховд үйлдвэрлэл технологийн паркийн цахилгаан хангамж, гол шугам сүлжээний ажил /Ховд, Жаргалант сум/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 2,174.4 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг,	2026	2026
12.	Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн барилга 10 ор /Ховд, Ховд сум 5 дугаар баг, Дунд ус/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 4,309.4 сая төгрөг, санхүүжих дүн 4,309.4 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр тус тус нэмж тусгах	2026	2027
Төсвийн тухай хуулийн 29¹ дүгээр зүйлийн 29¹.2.2-д заасан “барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх;” шаардлагад нийцэхгүй			
1.	Ажлын хэсгийн дэмжигдсэн саналын томьёоллын хавсралт 2-ын 5 дахь арга хэмжээ болох Аймгийн төвийн авто замын шинэчлэл /Ховд/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 10,000.0 сая төгрөг, санхүүжих дүн 3,300.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,251.6 сая төгрөгөөр бууруулж	2026	2028
2.	Сургуулийн барилга, 250 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Говил баг/		
3.	Сургуулийн барилга, 250 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Рашаант баг/		
4.	Бизнес инкубатор төвийн барилга /Ховд, Зэрэг сум/		

5.	Ганц модны голын төмөр бетон гүүр 72.8 у/м /Баян-Өлгий, Дэлүүн сум/		
6.	Дүүргийн хүүхдийн эмнэлгийн их засвар, шинэчлэл /Улаанбаатар, Баянгол дүүрэг/		
7.	Мал бэлтгэх тогтолцоо бүхий мах боловсруулах, экспортлох цогцолбор жишиг үйлдвэрийн ТЭЗҮ, зураг төсөв /Өвөрхангай, Хархорин сум/		
8.	Сумын төвийн авто зам, 1.2 км /Хөвсгөл, Алаг-Эрдэнэ сум/		
9.	Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 1.9 км /Орхон, Баян-Өндөр сум, Цагаанчулуут баг/		
10.	Сургуулийн барилга, 320 суудал /Архангай, Өлзийт сум/		
11.	Хангайн 1 дүгээр гудамжнаас Сэлбийн баруун эргийн далан хүртэлх хатуу хучилттай авто зам /Улаанбаатар/	2026	2026
12.	Хархорин, Цэцэрлэг чиглэлийн А0602 дугаартай авто замаас Батцэнгэл чиглэлд баригдаж байгаа замын төгсгөлөөс хүүхдийн Тамир зуслан-Батцэнгэл сумын төмөр бетон гүүр, мянганы замын хэвтээ тэнхлэгтэй холбох 62.04 км хатуу хучилттай авто замын эхлэл /Архангай/		
13.	Цагдаагийн гудамжийг УБЦТС-ын зүүн түгээх төвтэй холбох хатуу хучилттай авто зам /Улаанбаатар/	2026	2026
14.	Цагдаагийн гудамжны хойд талын хэвтээ тэнхлэгийн хатуу хучилттай авто зам /Улаанбаатар/	2026	2026

Эх сурвалж: ТБХ-ноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолол, 2025.11.07